

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/21/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас:70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нарантуул

Утас: 70432545

цахим хаяг: narantuuld@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
4.1 Залруулсан алдаа.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.08 № 3/08
танай _____ -ны № _____ -т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
Л.БИЛЭГДЭМБЭРЭЛ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэгслэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

021020146

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>43,419,765.74</u>	<u>29,750,543.80</u>
33	АВЛАГА	4,077,838.68	164,976.80
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	4,077,838.68	164,976.80
35	БАРАА МАТЕРИАЛ	39,341,927.06	29,585,567.00
351	Түүхий эд материал	76,500	76,500
35130	Эм боох материал	76,500	76,500
354	Хангамжийн материал	39,265,427.06	29,509,067
35410	Бичиг хэргийн материал	1,654,000	466,000
35420	Аж ахуйн материал	1,666,996	1,492,996
35430	Сэлбэг хэрэгсэл	2,148,000	2,448,000
35440	Түлш, шатах тослох материал	1,485,000	-
35460	Хүнсний материал	150,051	21,987
35470	Бусад хангамжийн материал	32,161,380.06	25,080,084
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>709,636,211.15</u>	<u>800,079,763.97</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	709,636,211.15	800,079,763.97
392	Биет хөрөнгө	654,873,711.15	745,213,514.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	636,483,028.00	724,468,121.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(64,614,347.85)	(81,556,042.29)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	80,000,000	80,000,000
39204	Хуримтлагдсан элэгдэл	(80,000,000)	(80,000,000)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	231,717,987.07	241,734,887.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	(173,235,384.87)	(196,686,621.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	90,422,281	130,620,451
39208	Хуримтлагдсан элэгдэл	(66,024,852.20)	(73,492,280.92)
39217	Ном	125,000	125,000
393	Биет бус хөрөнгө	54,762,500	54,866,249.92
39301	Программ хангамж	24,175,000	30,675,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(14,412,500)	(20,808,750.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	45,000,000	45,000,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>753,055,976.89</u>	<u>829,830,307.77</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>753,055,976.89</u>	<u>829,830,307.77</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	753,055,976.89	829,830,307.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	216,668,324	216,668,324
51101	Өмч: - төрийн	216,668,324	216,668,324
512	Хуримтлагдсан үр дүн	513,052,038.45	591,235,744.53
51210	Өмнөх үеийн үр дүн	513,052,038.45	514,461,413.65
51220	Тайлант үеийн үр дүн	-	76,774,330.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	23,335,614.44	21,926,239.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>753,055,976.89</u>	<u>829,830,307.77</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	810,209,303	1,019,591,399.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,504,000	208,720,299.32
120	Нийтлэг татварын бус орлого	40,504,000	208,720,299.32
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	40,504,000	208,720,299.32
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,504,000	57,576,161.32
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	151,144,138
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	769,705,303	810,871,100
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	736,030,900	799,136,100
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	736,030,900	799,136,100
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,659,500	11,735,000
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	16,659,500	735,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000	11,000,000
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,014,903	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,014,903	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	884,519,378.75	940,884,029.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	884,519,378.75	940,884,029.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	862,104,975.75	862,076,829.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	604,814,573.62	587,643,804.63
210101	Үндсэн цалин	604,814,573.62	587,643,804.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,530,327.46	80,338,368.57
210201	Тэтгэврийн даатгал	55,562,422.98	67,837,414.24
210202	Тэтгэмжийн даатгал	5,339,086.76	3,039,574.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,271,270.81	2,431,659.07
210204	Ажилгүйдлийн даатгал	964,068.81	550,865.86
210205	Эрүүл мэндийн даатгал	11,393,478.11	6,478,854.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,071,700	39,225,900
210301	Гэрэл, цахилгаан	4,429,600	5,846,800
210302	Түлш, халаалт	26,120,600	26,073,201
210303	Цэвэр, бохир ус	5,521,500	7,305,899
2104	Хангамж, бараа материалын зардал	47,091,000	27,168,896.06
210401	Бичиг хэрэг	22,245,900	4,026,300
210402	Тээвэр, шатахуун	4,476,650	8,084,800
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,379,600	1,266,000
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	439,000	445,100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,549,850	13,346,696.06
2105	Нормативт зардал	22,388,016.17	26,304,085
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,308,916.17	636,200
210502	Хоол, хүнс	20,714,600	25,207,385

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	364,500	460,500
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,487,550	3,723,650
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,804,150	3,425,900
210604	Урсгал засвар	1,683,400	297,750
2107	Томилолт, зочны зардал	4,250,000	-
210702	Дотоод албан томилолт	4,250,000	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,798,800	36,589,779
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,013,500	33,913,379
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000	16,000
210803	Даатгалын үйлчилгээ	1,415,000	1,440,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000	181,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	67,000	150,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	305,300	539,400
210807	Газрын төлбөр	263,000	350,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,673,008.50	61,082,346.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	6,590,000
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,673,008.50	54,492,346.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,414,403	78,807,200
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,414,403	76,750,400
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,014,903	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,354,000	75,914,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,045,500	836,400
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,056,800
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,056,800
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(74,310,075.75)</u>	<u>78,707,369.48</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,933,038.60
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,933,038.60
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(1,933,038.60)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(74,310,075.75)</u>	<u>76,774,330.88</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	49,441,485	-	49,441,485
C08	2019 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	216,668,324	23,335,614.44	513,052,038.45	753,055,976.89
D01	2020 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	216,668,324	23,335,614.44	513,052,038.45	753,055,976.89

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,409,375.20	1,409,375.20
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	216,668,324	23,335,614.44	514,461,413.65	754,465,352.09
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(1,409,375.20)	-	(1,409,375.20)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	76,774,330.88	76,774,330.88
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	216,668,324	21,926,239.24	591,235,744.53	829,830,307.77

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	804,821,400	872,525,100
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,995,000	61,654,000
120	Нийтлэг татварын бус орлого	40,995,000	61,654,000
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	40,995,000	57,576,161.32
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,504,000	57,576,161.32
120009	Бусад орлого	491,000	4,077,838.68
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	763,826,400	810,871,100
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	736,030,900	799,136,100
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	736,030,900	799,136,100
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,795,500	11,735,000
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,870,500	735,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,925,000	11,000,000
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	804,821,400	872,525,100
21	УРСГАЛ ЗАРДАЛ	804,821,400	872,525,100
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	776,623,900	793,717,900
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	583,991,300	590,659,200
210101	Үндсэн цалин	445,616,300	433,417,622.27
210102	Нэмэгдэл	121,075,286.58	139,569,457.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,299,713.42	17,672,120.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,029,800	78,499,800
210201	Тэтгэврийн даатгал	55,141,000	55,611,000
210202	Тэтгэмжийн даатгал	5,722,200	5,722,200
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,577,700	4,577,800
210204	Ажилгүйдлийн даатгал	1,144,500	1,144,400
210205	Эрүүл мэндийн даатгал	11,444,400	11,444,400
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,071,700	39,225,900
210301	Гэрэл, цахилгаан	4,429,600	5,846,800
210302	Түлш, халаалт	26,120,600	26,073,201
210303	Цэвэр, бохир ус	5,521,500	7,305,899

2104	Хангамж, бараа материалын зардал	21,088,850	10,001,600
210401	Бичиг хэрэг	6,302,000	2,838,300
210402	Тээвэр, шатахуун	8,965,150	2,054,800
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,673,600	1,266,000
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	540,700	444,100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,607,400	3,398,400
2105	Нормативт зардал	22,993,116	26,564,921
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,466,366	636,200
210502	Хоол, хүнс	20,086,750	24,819,621
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,440,000	1,109,100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,064,396	2,176,700
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,791,996	1,702,750
210604	Урсгал засвар	1,272,400	473,950
2107	Томилолт, зочны зардал	4,250,000	-
210702	Дотоод албан томилолт	4,250,000	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,134,738	36,589,779
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,220,438	33,913,379
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000	16,000
210803	Даатгалын үйлчилгээ	1,415,000	1,440,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000	181,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	67,000	150,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	434,300	539,400
210807	Газрын төлбөр	263,000	350,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,000,000
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,000,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,197,500	78,807,200
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,399,500	76,750,400
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,354,000	75,914,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,045,500	836,400
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,798,000	2,056,800
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,798,000	2,056,800
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	803,333,500	773,543,400	873,737,300	858,733,300
21	УРСГАЛ ЗАРДАЛ	803,333,500	773,543,400	873,737,300	858,733,300
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	779,681,000	753,143,900	794,930,100	781,982,900
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	583,991,300	583,991,300	590,659,200	590,659,200

210101	Үндсэн цалин	445,616,300	445,616,300	452,284,200	433,417,622.27
210102	Нэмэгдэл	120,714,400	121,075,286.58	120,714,400	139,569,457.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,660,600	17,299,713.42	17,660,600	17,672,120.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,029,800	78,029,800	78,499,800	78,499,800
210201	Тэтгэврийн даатгал	55,141,000	55,141,000	55,611,000	55,611,000
210202	Тэтгэмжийн даатгал	5,722,200	5,722,200	5,722,200	5,722,200
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,577,700	4,577,700	4,577,800	4,577,800
210204	Ажилгүйдлийн даатгал	1,144,500	1,144,500	1,144,400	1,144,400
210205	Эрүүл мэндийн даатгал	11,444,400	11,444,400	11,444,400	11,444,400
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,071,700	36,071,700	39,225,900	39,225,900
210301	Гэрэл, цахилгаан	4,429,600	4,429,600	6,212,300	5,846,800
210302	Түлш, халаалт	26,120,600	26,120,600	25,975,000	26,073,201
210303	Цэвэр, бохир ус	5,521,500	5,521,500	7,038,600	7,305,899
2104	Хангамж, бараа материалын зардал	11,752,300	10,726,350	11,836,900	10,001,600
210401	Бичиг хэрэг	2,647,000	2,647,000	2,838,300	2,838,300
210402	Тээвэр, шатахуун	4,326,400	3,704,650	3,349,200	2,054,800
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,248,600	1,248,600	1,266,000	1,266,000
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	518,700	518,700	444,100	444,100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,011,600	2,607,400	3,939,300	3,398,400
2105	Нормативт зардал	28,483,200	17,089,116.17	28,483,200	26,564,921
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,440,000	1,314,366.17	1,440,000	636,200
210502	Хоол, хүнс	25,603,200	14,334,750	25,603,200	24,819,621
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,440,000	1,440,000	1,440,000	1,109,100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,544,600	4,064,396	5,355,700	2,176,700
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,855,600	2,791,996	2,704,500	1,702,750
210604	Урсгал засвар	2,689,000	1,272,400	2,651,200	473,950
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,808,100	23,171,237.83	40,869,400	34,854,779
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,893,800	19,256,937.83	38,193,000	32,178,379
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000	1,485,000	16,000	16,000
210803	Даатгалын үйлчилгээ	1,415,000	1,415,000	1,440,000	1,440,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000	250,000	181,000	181,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	67,000	67,000	150,000	150,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	434,300	434,300	539,400	539,400
210807	Газрын төлбөр	263,000	263,000	350,000	350,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,652,500	20,399,500	78,807,200	76,750,400
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,652,500	20,399,500	78,807,200	76,750,400
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,607,000	19,354,000	77,970,800	75,914,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,045,500	1,045,500	836,400	836,400
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	803,333,500	773,543,400	873,737,300	854,655,461.32
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	736,030,900	732,548,400	799,136,100	797,079,300
131001	Улсын төсвөөс санхүүжих	736,030,900	732,548,400	799,136,100	797,079,300
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	67,302,600	40,995,000	74,601,200	57,576,161.32

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	67,302,600	40,995,000	74,601,200	57,576,161.32
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	51	51	51	51
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	41	41	41	41
620003	Үйлчлэх ажилтан	9	9	9	9
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	51	51	51	51
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	42	42	42	42
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9	9	9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

				Төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,260,267	11,735,000	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,260,267	11,735,000	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,067,834	11,735,000	
2104	Хангамж, бараа материалын зардал	13,746,454	-	
210401	Бичиг хэрэг	2,602,949	-	
210402	Тээвэр, шатахуун	10,116,505	-	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,027,000	-	
2105	Нормативт зардал	479,800	-	
210502	Хоол, хүнс	479,800	-	
2107	Томилолт, зочны зардал	9,384,500	-	
210702	Дотоод албан томилолт	9,384,500	-	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,345,080	1,735,000	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,345,080	1,735,000	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,000	10,000,000	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,000,000	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	112,000		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,192,433	-	
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,192,433		
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,192,433		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33,727,834	11,735,000	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,727,834	11,735,000	
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,919,334	735,000	
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	3,254,000		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,554,500	11,000,000	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2022 оны 01 дүгээр сарын 31-нээс 2021 оны 02 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 25 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн иргэдэд түргэн шуурхай хүргэх” гэсэн зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээг зорилтот бүлэгт цахимаар түргэн шуурхай хүргэх,*
- *Иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэх,*
- *Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлогын хэрэгжилтийг хангах,*
- *Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангах,*
- *Залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, үр дүнг нэмэгдүүлэх,*
- *Өрхийн үйлдвэрлэл эрхлэгч, аж ахуй нэгж, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр бичил бизнес эрхлэгчдэд жижиг зээл олгох арга хэмжээг зохион байгуулах,*
- *Үндэсний монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх,*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дотоод хяналт аудитын хэлтсээс Ковид-19 цар тахалтай холбоотой ХХҮГ-т дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 1,019,591.4 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 20,391.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 16,313.4 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 76,824.4 сая төгрөгөөр буюу 10.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Авлагын данс оны эхэнд 4,077.8 мянган төгрөгийн байсныг оны эцэст 165.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, авлага өмнөх оноос 3,912.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 29,585.6 мянган төгрөг болж 9,756.3 мянган төгрөгөөр буурсан нь 9,093.2 мянган төгрөгийн бусад хангамжийн бараа материалыг акталж устгасантай холбоотой байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 44,216.9 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 4,275.2 мянган төгрөгийн бараа материалыг бэлтгэн нийлүүлэгч болон дээд шатны байгууллагаас нийт 48,492.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, 58,248.5 мянган төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 709,636.2 мянган төгрөг байсан бол тайлант оны эцэст 800,079.7 мянган төгрөг болж 90,443.5 мянган төгрөгөөр өссөн нь

ХХҮЕГ-ын хөрөнгө оруулалтаар барилгын засварын ажил хийгдсэн, үнэ төлбөргүйгээр тоног төхөөрөмж олгосонтой холбоотой байна.

Тайлант онд 146,868.9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан, 2,168.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгаж тайлант оны эцэст 1,252,623.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 753,055.9 мянган төгрөг байсан оны эцэст 829,830.3 мянган төгрөг тайлант онд 76,774.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үед ашигтай ажилласантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,144,239.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,144,239.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгаалал яамнаас тус байгууллагын төсвийг 873,737.3 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 873,737.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 799,136.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 74,601.2 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 797,079.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 57,576.2 мянган төгрөг нийт 854,655.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 858,733.3 мянган төгрөгийг зарцуулж 2,056.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 854,655.5 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь хангамж, бараа материалын зардал 1,835.3, томилолтын зардал 1,918.3, эд хогшил, урсгал засварын зардал 3,179.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 10,092.5 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Туслах үйл ажиллагааны орлогыг 74,601.2 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 57,576.2 мянган төгрөгөөр 77.2 хувьтай буюу 17,024.9 мянган төгрөгөөр дутуу бүрдүүлсэн нь “Цагаан уул” сувиллын үйл ажиллагаа Ковид-19 цар тахалтай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт тайлангийн тайлангаар халамжийн сангаас өрхийн судалгааны зардалд 11,000.0, цахим худалдан авах ажиллагааны орлогоор 735.0 мянган төгрөг нийт 11,735.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 701.8-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 147 хугацаандаа оруулсан 4 мэдээлэл хугацаа болоогүй, хугацаа хоцроосон мэдээлэлгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлого, зарлагын ажил гүйлгээг тухай бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4,077.8 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,936.7 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, тайлант үеийн үр дүнг 100.0 мянган төгрөг,
2. Санхүүгийн байдлын тайланд барилга байгууламж, тавилга эд хогшлын хуримтлагдсан элэгдлийг 6,836.7 мянган төгрөг,

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 2021 оны санхүүгийн тайланд залруулга хийсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.


Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс									
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	2	6936.7	2	6,936.7								

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН

АХЛАХ АУДИТОР:  Д.НАРАНТУУЛ



